

Код: 13190619

Харилцагч:

тлр: ПҮРЭВДОО.ГАНЗУЛ(1757)/1049
(1073)



Төрийн банк

МЕМОРИАЛЫН БАРИМТ № 20170309625700446457 - 0
Банк хоорондын гүйлгээ

Дебит	1060 - ТБ БАЙГУУЛЛАГЫН БАНК				2017.02.17
	АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР				
	DP	340004010398	зарлага	*****4,154.53	USD 2,472.00
Кредит	040000 - Худалдаа хөгжлийн банк - Худалдаа хөгжлийн банк				
	ММС АССОЦИАЦИ				
	BA	457039015		*****10,270,000.00	MNT 1.00

Гүйлгээний дүн (үсгээр) дөрвөн мянга нэг зуун тавин дөрвөн доллар тавин гурван цент

Гүйлгээний утга: **ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРТ**

Теллер:

Харилцагч:



Handwritten notes:
10000 x 10000
2017.03.09

НЭХЭМЖЛЭХ № 008

Нэхэмжлэгч:

Төлөгч:

Байгууллагын нэр Эм Эм Ар Эй ТББ

Байгууллагын нэр _____

Авлигатай тэмцэх газар

Хаяг УБ хот, БЗД, 3-р хороо,
Их тойруу, ХД-43-01

Хаяг _____

Гэрээний № _____

Утас _____

Нэхэмжилсэн огноо 2016.10.21

Факс _____

Төлбөр хийх хугацаа _____

Э шуудан davaaxxi@yahoo.com

Банкны нэр Худалдаа хөгжлийн банк

Дансны дугаар 457039015-төгрөг


№	Гүйлгээний утга	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Үйлчилгээний төлбөр	1	10,270,000	10,270,000.00
			Дүн	10,270,000.00

Мөнгөний дүн Арван сая хоёр зуун далан мянган төгрөг

(үсгээр)

болно.

Гамга



Дарга.......... Д.Амгаланбаатар

Нягтлан бодогч.....

БАТЛАВ
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР

.....
З.БААСАННЯМ

БАТЛАВ
“МОНГОЛЫН МАРКЕТИНГИЙН
СУДАЛГААНЫ АССОЦИАЦИ” ТББ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....
Б.АМГАЛАНБААТАР

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2016 он 10 сарын 05-ны өдөр

№ *118*

Улаанбаатар хот

Энэхүү Ажил гүйцэтгэх гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г Монгол Улсын Иргэний хуулийн 343-346 дүгээр зүйлүүдийг үндэслэн,

Нэг талаас 2010644 регистрийн дугаартай, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сөүлийн гудамж-41 орших Авлигатай Тэмцэх Газар (цаашид “Захиалагч” гэх);

Нөгөө талаас 8117357 регистрийн дугаартай, Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 3-р хороо, Их тойруу, 57-1-р байр, 2 давхарын 201 тоот хаяганд орших “Монголын маркетингийн судалгааны ассоциаци” ТББ (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нар (Хамтад нь “Талууд” гэх) дор дурьдсан нөхцлүүдийн талаар харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Гэрээний зүйл

1.1 Энэ гэрээгээр Гүйцэтгэгч гэрээний Хавсралт 1-т заасан шаардлага бүхий “зохион байгуулалт” (цаашид “үйлчилгээ” гэх)-г үзүүлж Захиалагчид онол практикийн бага хурлыг чанартай үр бүтээмжтэй зохион байгуулах, Захиалагч уг ажлын үнийг Гүйцэтгэгчид төлж барагдуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

Хоёр. Онол практикийн бага хурлыг зохион байгуулахад тавигдах шаардлага, үйлчилгээний үнэ, төлбөр төлөх нөхцөл, хугацаа, хүлээлцэх

2.1 Гүйцэтгэгчээс Захиалагчид нийлүүлэх үйлчилгээ нь Гэрээний Хавсралт 1-т дурдсан шаардлагыг хангасан байх, урд нь ашиглагдаагүй шинэ байх, биет байдлын болон эрхийн доголдолгүй байхыг Гүйцэтгэгч хариуцна.

2.2 Гэрээний дагуу онол практикийн бага хурлыг 2016 оны 10 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгуулна.

2.4 Захиалагч үйлчилгээний нийт үнэ болох 10,270,000 /арван сая хоёр зуун далан мянга/ төгрөгийг гэрээ болон зохион байгуулалтын үйлчилгээ үзүүлсэн тухай актыг үндэслэн төлнө.

2.4.1 Энэхүү гэрээт ажлыг хийж гүйцэтгэсэн тухай 2 талын актыг үндэслэн, урьдчилгаа төлбөр өгөхгүйгээр ажлын 8 хоногийн дотор үйлчилгээний нийт үнэ болох 10,270,000 /арван сая хоёр зуун далан мянга/ төгрөгийг Гүйцэтгэгч байгууллагын Худалдаа хөгжлийн банкин дахь 457039015 тоот дансанд шилжүүлнэ.

2.5 Гэрээний 2.4-т заасан нийт үнэд тээврийн зардал, онцгой албан татвар, гаалийн татвар, нэмэгдсэн өртгийн татвар зэрэг зардал орсон байна. Гэрээний хугацаанд захиалгат үйлчилгээний үнэд өөрчлөлт орох, мөнгөний ханш унах, мөнгөн масштабт өөрчлөлт орсон нь үйлчилгээний нийт үнийг өөрчлөх үндэслэл болохгүй.

.....
[Signature]

Талуудын гарын үсэг

.....
[Signature]

хугацаанд захиалгат үйлчилгээний үнэд өөрчлөлт орох, мөнгөний ханш унах, мөнгөн масштабт өөрчлөлт орсон нь үйлчилгээний нийт үнийг өөрчлөх үндэслэл болохгүй.

2.6 Зохион байгуулалтын үйлчилгээг гадаад улс орнуудын загварын дагуу гүйцэтгэж гэрээний хугацаанд нь гүйцэтгэж захиалагчид хүлээлгэн өгнө.

2.7 Гүйцэтгэгч зохион байгуулалтын үйлчилгээг Захиалагчийн талд шилжүүлэхтэй холбогдсон зардлыг бүрэн хариуцна.

Гурав. Гүйцэтгэгчийн эрх үүрэг

3.1 Гүйцэтгэгчийн хүлээх үүрэг нь:

3.1.1 Энэ гэрээний Хавсралтад заасан үзүүлэлт бүхий зохион байгуулалтын арга хэмжээг бүрэн эрхийн доголдолгүй үйлчилгээг Захиалагчид хүлээлгэн өгөх;

3.1.2 Захиалагчаас өгсөн саналыг Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхгүй;

3.1.3 Гүйцэтгэгч зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө гаргаж захиалагчаар хянуулан баталгаажуулах;

3.1.4 Гүйцэтгэгч үйлчилгээг хүлээж авахдаа үйлдвэрлэлийн технологиос шалтгаалан зайлшгүй хийх өөрчлөлтийг захиалагчтай зөвшилцөх;

3.1.5 Хэрэв гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн бус буюу зохих ёсоор биелүүлэх боломжгүй бол ажил гүйцэтгэхэд гарч буй саад бэрхшээлийн талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэх;

3.1.6 Захиалгат үйлчилгээг Захиалагчийн өмчлөлд шилжүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг хариуцах;

3.2 Гүйцэтгэгчийн эрх нь:

3.2.1 Энэ Гэрээнд заасан хугацаанд зохион байгуулалтын үнийг төлөхийг Захиалагчаас шаардах;

3.2.2 Хуульд заасан бусад эрх;

Дөрөв. Захиалагчийн эрх, үүрэг

4.1 Захиалагчийн хүлээх үүрэг нь:

4.1.1 Энэ Гэрээнд заасан хугацаанд биет байдлын болон эрхийн доголдолгүй үйлчилгээг хүлээн авч зохих үнийг төлөх;

4.1.2 Захиалагч үйлчилгээг чанарын шаардлагыг заасан захиалгын хуудсыг гүйцэтгэгчид өгөх;

4.1.3 Энэ Гэрээ болон хуульд заасан бусад үүрэг;

4.2. Захиалагчийн эрх нь:

4.2.1 Энэ Гэрээнд заасан үйлчилгээнд загварт зөвшөөрөлгүй өөрчлөлт оруулсан, өнгө нь зөрсөн, чанарын шаардлага хангаагүй буюу биет байдлын болон эрхийн доголдолтой үйлчилгээг хүлээн авахгүй байх;

4.2.2 Гүйцэтгэгчийн ажлын явцын талаарх мэдээллийг авах, зааварчилгаа өгөх, хяналт тавих;

4.2.3 Захиалагчид үйлчилгээг холбогдох төлбөрийг нь төлөхгүй байх буюу төлсөн төлбөрөө Гүйцэтгэгчээс буцааж нэхэмжлэх, чанарын шаардлага хангаагүй үйлчилгээг шаардлага хангасан үйлчилгээгээр солиулахыг Гүйцэтгэгчээс шаардах;

4.2.4 Үйлчилгээний доголдолыг арилгуулах буюу доголдолгүй тухайн үйлчилгээгээр солиулах, доголдолыг арилгахад гарсан зардлаа төлүүлэх, эсхүл гэрээг нэг талын санаачлагаар цуцалж учирсан хохирлоо нөхөн төлүүлэх;

4.2.5 Үйлчилгээний чанарын дутагдлын талаар Гүйцэтгэгчид гомдол гаргах, үүнээс үүдэн учирсан хохирол, чирэгдлийг шийдвэрлэхэд хамтран ажиллахыг Гүйцэтгэгчээс шаардах;



Талуудын гарын үсэг



4.2.6 Хуульд заасан бусад эрх.

Тав. Хариуцлага

5.1 Гүйцэтгэгч энэ Гэрээний 2.3-д заасан хугацаанд захиалгат үйлчилгээг Захиалагчид нийлүүлээгүй бол Гүйцэтгэгч гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.3 хувийн алдангийг Захиалагчид төлнө.

5.2 Захиалагч энэ Гэрээний 2.4-д заасан үйлчилгээний төлбөрийг Гүйцэтгэгчид төлөөгүй бол Захиалагч нь гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс хоног тутамд 0.3 хувийн алдангийг Гүйцэтгэгчид төлнө.

5.3 Гэрээтэй холбоотой олсон орлогоос хууль тогтоомжийн дагуу төлөх Гүйцэтгэгчийн татварын үүргийг Захиалагч хариуцахгүй.

5.4 Гүйцэтгэгч Гэрээний 2.3-д заасан хугацаанд үйлчилгээг нийлүүлэх хугацааг 10 хоногоор хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч Гэрээг нэг талын санаачлагаар цуцалж, төлсөн төлбөр болон үйлчилгээний нийт үнийн дүнгийн 10 хувьтай тэнцэх торгуулийг Гүйцэтгэгчээр төлүүлнэ.

5.5 Талуудын аль нэг Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол үүнээс үүдэн нөгөө талд болон бусдад учирсан хохирол, зардлыг бүрэн хариуцаж барагдуулна.

5.6 Гэрээг хэрэгжүүлэх явцад давагдашгүй /үер, ус, салхи, шуурга г.м/ хүчин зүйлсийн үйлчлэлээс хамаарсан хариуцлагыг Захиалагч хариуцахгүй.

Зургаа. Маргаан шийдвэрлэх

6.1 Гэрээнээс үүдэн гарч болох аливаа маргааныг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

6.2 Талууд Гэрээний 6.1-д заасан аргаар маргааныг шийдвэрлэж чадахгүй бол Монголын Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Долоо. Бусад

7.1 Гэрээ нь Талуудын бүрэн эрхт төлөөлөгчид гарын үсгээ зурж, тэмдгээ дарснаар хүчин төгөлдөр болж, Гэрээг цуцалснаар буюу Гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэнээр дуусгавар болно.

7.2 Талуудын аль нэг нь Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн эсвэл хэсэгчлэн биелүүлээгүй бол нөгөө талын санаачлагаар Гэрээг цуцалж болно.

7.3 Гэрээг хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь хуулийн адил хүчинтэй байна.

7.4 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож, шинээр нэмэлт гэрээ байгуулах замаар шийдвэрлэнэ.

7.5 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, Гэрээг цуцлах саналаа нөгөө талдаа 7-оос доошгүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагчийг толоолж:



Гүйцэтгэгчийг төлөөлж:

Талуудын гарын үсэг



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ
АЛБАНЫ АЖИЛТАН,
КОМИССАР


.....

Д.БАТ-ОРГИЛ

“МОНГОЛЫН МАРКЕТИНГИЙН
СУДАЛГААНЫ АССОЦИАЦИ” ТББ

УЛААНБААТАР ХОТ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА


.....

О.СУМБЬЯА


.....

Талуудын гарын үсэг


.....